

### **Хөв цөөрөм байгуулсан тухай**

Говийн бага Дархан цаазат газрын “А” хэсгийн Зээргэнэт, Таван алдын тал, Өндөр богд уул, Үнэгэт, Шар заг зэрэг газруудын зэрлэг амьтад болох Хулан, Харсүүлтий зэрэг амьтдад зориулан усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, тэдний бэлчээрт Байгаль орчин ногоон хөгжлийн яамны санхүүжилтээр Сэргээгдэх эрчим хүчийг ашиглан Хөв цөөрөм байгуулан ажиллаа. Тухайн хөв цөөрмийг гэрийн тэжээвэр амьтнаас хамгаалахын тулд хашаажуулан тохижууллаа.

Энэ газар нь амьтад уух, ундаалах усгүй байсан бол одоо уух ус идээшлэх бэлчээр нь нэг дор болж тухайн орчимд нутагших нөхцөл бүрдэж байна.



---

### **Сэргээгдэх эрчим хүчийг ашиглан Хөв цөөрөм байгуулсан тухай**

Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд Дунар-Од ХХК БОНХЯ-тай байгуулсан гэрээний дагуу нарны эрчим хүчээр зун, өвөлийн аль ч улиралд ажиллах боломжтой гүний худгийн насос суурилуулж усан сан буюу хөв хийж Хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өглөө.